



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим
арга хэмжээний тухай

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчиж зөвшөөрөлгүйгээр 250.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4, 8.5, 21, 48.1, 49 дүгээр зүйлийн холбогдох заалтыг зөрчиж, 1,680.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, орон нутгийн өмчийн хөрөнгөд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 2016-2017 онд 183.3 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт хийсэн зэрэг нийт 2,614.1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Банзрагчид дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

2.2. Орон нутгийн өмчийн хөрөнгөд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 2016 оноос өмнө 81.7 сая төгрөгийн, 2016 онд 49.1 сая төгрөгийн, 2017 онд 52.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснийг төрийн өмчид ногдох дүнгээр баталгаажуулах, бүртгэх арга хэмжээ авах;

2.3. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.4. Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу байгуулах, төсөвт ногдох хувийг төвлөрүүлэх;

0000121

2.5.Байгууллагад хөтлөгдөж буй албан баримт бичиг, гэрээ, хэлцэл, эрх зүйн актыг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, зааврын дагуу боловсруулах, бүрдүүлэх, хадгалах;


2.6.Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах;

2.7.Дээд байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллах.


2.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн
6.4 дугаар тогтоолын хавсралт

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1. Хөрөнгө оруулалт, түүнтэй холбоотой зөрчил					
1	Тайлант онуудад баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан	2016-2017 он	250.7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, компанийн санхүүгийн эх үүсвэр, бодит хэрэгцээг тооцож баталгаажуулсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах, батлуулах.
2	Бусдын хөрөнгөд /орон нутгийн өмч/ эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийсэн, хөрөнгө оруулалтыг баталгаажуулаагүй	2014-2017 он	183.3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Хөрөнгө оруулалтын төрийн өмчид ногдох хэсгийг баталгаажуулах арга хэмжээ авах, хөрөнгөөр бүртгэх. Хөрөнгө оруулалт хийхдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч хийх.
2. Худалдан авалт, гэрээ, хэлцэлтэй холбоотой зөрчил					
3	2016, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хянуулж, батлуулаагүй	2016-2017 он	-	Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.6 дахь хэсэг	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулах, мөрдөн ажиллах.
4	2016 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа 8 үнэлгээний хороо байгуулсан боловч үнэлгээний хорооны гишүүдийн “1”-с бусад гишүүн нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй, “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, Захиалагч тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалаагүй.	2016-2017 он	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.6 дахь хэсэг, 47.8 дахь хэсэг, 49.1 дэх хэсэг	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
5	Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй шууд худалдан авалт хийсэн.	2016-2017 он	686.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4 хэсэг	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
6	Худалдан авах ажиллагаанд тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхдээ үнэлгээний хороо нь харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендер шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болох боловч	2016-2017 он	116.7	Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалын 2-д заасан “Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх үед үнийн санал авах баримт бичгийг боловсруулж ажиллахыг захиалагчид даалгасан заалтыг зөрчсөн.	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.

	дээрх тушаалын дагуу дахин үнийн санал авах баримт бичиг боловсруулан, урилга хүргүүлж, хэлэлцээр хийх ажиллагааг явуулалгүйгээр гэрээ шууд байгуулсан.				
7	Захиалагч энэ хуульд заасан журмын дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулаагүй.	2016-2017 он	275	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 46.1.2 дахь заалт	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
8	Тендерийн баримт бичиг боловсруулалгүй, урилга хүргүүлэлгүйгээр үнэлгээний хорооны хүчин төгөлдөр бус шийдвэрийг үндэслэн, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ шууд байгуулсан.	2017 он	256.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.1 дэх заалт	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
9	Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээгүй, Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй.	2016-2017 он	223.3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1, 8.4 дэх заалт	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
10	Компани 2016, 2017 онд БНХАУ-ын Эрэн хотоос үйлдвэрлэлийн үндсэн сэлбэг материал, бусад хөрөнгийг тендер сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авсан.	2016-2017 он	122.3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5, 8.1 дэх хэсэг	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
11	2016-2017 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр ажил гүйцэтгүүлсэн нь зарим этгээдэд давуу эрх олгосон.	2016-2017 он	369.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2016-2017 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгах, худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллах.
3. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээтэй холбоотой зөрчил, дутагдал					
12	Иргэн, хуулийн этгээдээр нүүрс тээвэрлэх ажил гүйцэтгүүлэн их хэмжээний мөнгийг бэлнээр олгосон.	2016-2017 он	130.2	Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын үйл ажиллагааны журам	Бэлтгэн нийлүүлэгчтэй хийх тооцоог бэлнээр бус дансаар олгох, мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.
НИЙТ ДҮН:			2614.1		